



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны  
зохицуулалтын журам, заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичиг хүлээн авах, хянах заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2015 оны "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар батлах тухай" 409 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮҮШЭТГЭГЧ  
ДЭД ДАРГА  О. БАТБОЛД



Санхүүгийн зохицуулах хорооны  
2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн  
71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, хүсэлт бүртгэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, баримт бичиг бүрдүүлэх болон баримт бичгийг хүлээн авах, хянах зааврыг Хорооны тогтоолоор батална.

~~1.3. Банк бус санхүүгийн байгууллага /цаашид "ББСБ" гэх/-ыг эрхэлж байгаа үйл ажиллагааны төрлөөс нь хамааруулан дараах байдлаар 3 ангилна:~~

~~1.3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6, 7.1.7 д заасан үйл ажиллагааг төрөлжүүлэн эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Валют арилжааны ББСБ”;~~

~~1.3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7 д заасан үйл ажиллагааг төрөлжүүлэн эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Зээл, санхүүжилтийн ББСБ”;~~

~~1.3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11 д заасан үйл ажиллагааг төрөлжүүлэн эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Хөрөнгийн удирдлагын ББСБ”.~~

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 10 - ны өдрийн 92 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

1.4. ББСБ нь энэ журмаар тогтоосны дагуу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11 дэх заалтад заасан үйл ажиллагааг эрхэлж болно. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлж байгаа хуулийн этгээд нь Компанийн тухай хуульд зааснаар компаниудын нэгдлийн оролцогч байж болно.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 10 -ны өдрийн 92 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

1.5. ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон бусад нөхцөл, хязгаарлалтыг олон улсын стандартад нийцүүлэн Хороо тогтооно.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 10 -ны өдрийн 92 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

1.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгохдоо Хороо дараах зарчмыг баримтална:

1.6.1. алслагдсан дүүрэг, хөдөө орон нутагт хямд өртөгтэй олон төрлийн санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэх ББСБ-уудыг дэмжих бодлого, зохицуулалт, хэм хэмжээг тогтоох;

1.6.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хүрээнд олон улсын санхүүгийн

байгууллагуудын гаргасан зөвлөмж, аргачлал, стандартад нийцсэн зохицуулалтыг бий болгох;

1.6.3.санхүүгийн олон төрлийн ажил үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэдэг активын удирдлагыг эрсдэлгүй хэрэгжүүлэх чадавх бүхий санхүүгийн байгууллагыг хөгжүүлж, шударга өрсөлдөөнт, тогтвортой, хүртээмжтэй зах зээлийн орчинг бий болгох.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 10 - ны өдрийн 92 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

### **Хоёр. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

2.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна.

2.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг Компанийн тухай хуулийн 13, 18 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх (цаашид өөрчлөн байгуулах гэх) замаар, хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулж болно.

2.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1 дэх хэсэг болон 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

2.4. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-д Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан шаардлагыг тавих бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хорооноос нэмэлт шаардлага тавьж болно.

2.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа тус бүрийг нарийвчлан зохицуулсан бодлогын баримт бичиг, журам, зааврыг баталж, мөрдөн ажиллана.

2.6. Хувьцаа эзэмшигчдээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хөрөнгө оруулагчаас хоёрдогч өглөгөөр оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн иргэний хууль ёсны орлого, хуулийн этгээдийн хувьд санхүүгийн жилийн үйл ажиллагааны цэвэр ашиг болон хуримтлагдсан ашиг байна.

2.7. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллана.

2.8. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр хугацаанд нь төлнө.

2.9. Үйл ажиллагааны шаардлагыг хангасан техник, тоног төхөөрөмжтэй байна.

2.10. Банк бус санхүүгийн байгууллага нь тусгай зөвшөөрөл авснаас хойш 3 сарын дотор нягтлан бодох бүртгэлийн програмаар хангагдаж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчдийн мэдээллийг солилцож эхэлсэн байна.

2.11. Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд ББСБ-ын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

~~2.12. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад дараах нэмэлт шаардлагыг тавина:~~

~~2.12.1.ажилтны аюулгүй байдлыг хангасан төрөн /шилэн/ хаалттай байх;~~

~~2.12.2. бичсэн бичлэгийг 1 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын камертай байх;~~

~~2.12.3. гадаад валютыг худалдах, худалдан авах тухай бүр баримт үйлдэж, тооцооллыг хийх боломжтой санхүүгийн програм, кассын машинтай байх;~~

~~2.12.4. тухайн төрлийн валютыг шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;~~

~~2.12.5. гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийг нийгэд ил төд мэдээлэх самбартай байх.~~

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 495 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

2.13. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад дараах нэмэлт шаардлагыг тавина:

2.13.1. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын мөнгөн дүн, үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөлийг баталсан байх;

2.13.2. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;

2.13.3. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэхдээ нууцлал бүхий хяналтын системтэй байх.

2.14. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад дараах нэмэлт шаардлагыг тавина:

2.14.1. нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

2.14.2. энэ журмын 2.14.1-д заасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

2.14.3. хөрөнгийг удирдах туршлага бүхий, эрсдэлийн үнэлгээ, активын удирдлагын суурь тооцооллыг хийх чадвартай, санхүү, хөрөнгө оруулалт эсхүл хууль эрх зүйн салбарт 5-аас доошгүй жил ажиллаж мэргэшсэн боловсон хүчин, хүний нөөцтэй;

2.14.4. итгэл хүлээлгэгчийн активыг хянах, ашиглах, захиран зарцуулах доод хугацаа 6 сараас доошгүй байх;

2.14.5. хөрөнгө (мөнгөн хөрөнгө, бусад актив) итгэмжлэн удирдах дүрэм, журамтай байх;

2.14.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг удирдах бол тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан байх.

2.15. Дараах үйл ажиллагаа явуулахыг итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-д хориглоно:

2.15.1. Хорооноос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ нь итгэл хүлээлгэгчийг татах зорилгоор олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, сурталчилгаа явуулах, ашиг /үр шим/ олгох талаар олон нийтэд урьдчилан амлах;

2.15.2. итгэмжилсэн хөрөнгийг Хорооноос зөвшөөрөл аваагүй бусад санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулах;

2.15.3. итгэл хүлээгч нь итгэмжилсэн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр тогтоосон нөхцөлийг зөрчиж итгэл хүлээлгэгч болон хувь хүртэгчийн хууль бус ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах;

2.15.4. хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах хүсэлтэй итгэл хүлээлгэгчийн санал болгож байгаа нөхцөл, шаардлагыг итгэл хүлээгчийн эрх ашигт албадан нийцүүлэх аливаа оролдлого хийх;

2.15.5. хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр татсан хөрөнгийг бусад этгээдэд итгэлцлийн үйлчилгээгээр шилжүүлэх.

2.16. Итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ нь итгэл хүлээлгэгчтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу тэдгээрийн хөрөнгө (бэлэн мөнгө, зээл, бусад актив)-ийг дараах хэлбэрээр удирдаж болно:

2.16.1. зээл олгох, гадаад валют худалдан авах;

2.16.2. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн бичиг, компанийн хувьцаа, компанийн өрийн бичиг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, үл хөдлөх эд хөрөнгө болон үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших эрх зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах;

2.16.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу тусгай зориулалтын компани үүсгэн байгуулж актив хөрөнгөө багцлан, түүнд суурилсан өрийн хэрэгсэл гаргах;

2.16.4. хөрөнгө (актив)-ийн чанарыг сайжруулах, дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн санхүүжилт хийх, компанийг нэгтгэх, нийлэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах**

3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02001-ийн дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (А)-д заасан хавсаргах баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлж Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

3.2. Хорооны тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, ажлын 30 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.3. Хорооны хуралдаан болохоос 2 өдрийн өмнө хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг банкн дахь тухайн хуулийн этгээдийн нэг дансанд төвлөрүүлэн байршуулсан банкны тодорхойлолт, дансны хуулгыг авч баталгаажуулсан байна.

3.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн хуулийн этгээдийн эрхлэх банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрлийг тодорхой тусгана.

3.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

3.6. Хорооны шийдвэрийг үндэслэн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт бүртгүүлж, тамга тэмдэг авснаар үйл ажиллагаа эхлүүлсэнд тооцно.

3.7. Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт бүртгүүлж нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар эсхүл, эх хувийг Хороонд ирүүлнэ.

3.8. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй эсхүл дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

3.8.1. хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь нотлогдсон;

3.8.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

3.8.3. хувьцаа эзэмшигч /хувьцаа эзэмшигчид/ нь зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өртэй;

3.8.4. хувьцаа эзэмшигч /хувьцаа эзэмшигчид/, эрх бүхий албан тушаалтнууд нь шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгэл эдэлж байгаа нь тогтоогдсон;

3.8.5. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг энэхүү журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь хүсэлт тавьсан өдрөөс хойш 6 сарын хугацаа өнгөрсөн;

3.8.6. энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

3.9. Өргөдлийн мэдээлэл, бүрдүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмж тодруулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Хороо энэ талаар албан бичгээр мэдэгдэж, нэмэлт мэдээлэл, баримт бичиг авч болох бөгөөд хууль журмын шаардлагын дагуу нэмж бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

3.10. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.11. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш тухайн хүсэлт гаргагч хуулийн этгээдээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

#### **Дөрөв.Тусгай зөвшөөрөл нэмж олгох, олгохоос татгалзах**

4.1. Банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа нэмж эрхлэхийг хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн маягт СЗХ02001-ийн дагуу өргөдөл гаргах бөгөөд 2 дугаар хавсралт (Б)-д заасан баримт бичгийг хавсарган Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

4.2. Хороо дараах нөхцөл, шаардлагыг хангасан ББСБ-д тодорхой нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгож болно:

4.2.1. холбогдох хууль тогтоомж, журам, зааварт заасан шаардлагыг бүрэн хангасан;

4.2.2. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтад хамрагдсан бол сайн болон хангалттай үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан;

4.2.3. Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 6 ба түүнээс дээш сарын хугацаанд хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан;

4.2.4. санхүү, төлбөрийн чадвар, нэр хүнд болон хувь нийлүүлэгчдийн бизнесийн ёс зүй нь уг үйл ажиллагааг эрхлэхэд харшлахгүй гэж үзсэн.

4.3. Итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж авах ББСБ нь энэ журмын 4.2.1-4.2.4-д заасан нөхцөл шаардлагыг хангахаас гадна 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, сүүлийн 4 улирал дараалан ашигтай ажилласан байна.

4.4. ББСБ-аас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, ажлын 30 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

4.6. ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

4.7. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа нэмж эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаар гарсан Хорооны шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хүсэлт гаргагч ББСБ-д албан бичгээр хүргүүлнэ.

4.8. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж олгохоос татгалзсан тохиолдолд нөхцөл шаардлага хангасны дараа тухайн ББСБ-аас банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж эрхлэх хүсэлтийг дахин энэ журмын дагуу гаргаж болно.

### **Тав. Бусад зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах**

~~5.1. Хувь нийлүүлсэн хоронгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах:~~

~~5.1.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.5-д заасны дагуу ББСБ нь хувь нийлүүлсэн хоронгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр аливаа гүйлгээ хийгдэхээ өмнө зөвшөөрөл авна.~~

~~5.1.2. зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан өргөдлийн маягт СЗХ02002-ын дагуу өргөдөл гаргах ба 2 дугаар хавсралт (В)-д заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.~~

~~5.1.3. ББСБ нь хувь нийлүүлсэн хоронгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнийг дараах тохиолдолд өөрчилж болно:~~

~~5.1.3.а. ББСБ-ын тайлант жилийн ангаас хуваарилагдсан ногдол ангаар нэмэгдүүлэх;~~

~~5.1.3.б. хувьцаа эзэмшигчид нэмэлт хоронго оруулах;~~

~~5.1.3.в. шинээр хувьцаа гаргах;~~

~~5.1.3.г. хувьцаа эзэмшигчээ оруулсан хувьцааг Иргэний хуульд заасны дагуу овлүүлэх, бэлэглэх, өөр хоорондоо болон гуравдагч этгээдэд худалдах;~~

~~5.1.3.д. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хоронгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, толборийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хоронгийн хэмжээг хөрөгдуулах.~~

~~5.1.4. хувь нийлүүлсэн хоронгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүсч ББСБ-аас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар" т заасны дагуу хянаж, хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.~~

~~5.1.5. хувь нийлүүлсэн хоронгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний~~

хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад хөлбөгдөх бүртгэлийг хийлгэнэ.

5.1.6. ББСБ нь өөрчлөлт өрсөн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

5.1.7. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй хөлбоотойгоор мөнгөн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдохгүй, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ хэлцэл нь хуурамч тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзана.

5.1.8. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

*/Энэ бүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 10 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

5.2. Хоёрдогч өглөгийн зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах:

5.2.1. “хоёрдогч өглөг” гэж өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, 3-дагч этгээдээс авсан, захиран зарцуулалт нь хязгаарлагдмал мөнгөн хөрөнгийг хэлнэ.

5.2.2. хоёрдогч өглөгийн зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02002-ийн дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Г)-д заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.2.3. ББСБ-аас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.2.4. хоёрдогч өглөгийн гэрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвөх нөхцөлийг тусгасан байна.

5.2.5. хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буугдсан, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.

5.2.6. хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулагч этгээдийн гэрээний эрх шилжих тохиолдолд ББСБ нь энэ журмын 5.2.2-т заасны дагуу Хороонд хандаж зөвшөөрөл авна.

5.2.7. хороо ББСБ-аас ирүүлсэн энэхүү журмын 5.2.2-д дурдсан баримт бичгүүд нь зохих нөхцөл, шаардлагыг хангаагүй үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

5.2.8. хоёрдогч өглөг татах зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

5.3. Нэгж байгуулах зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох:

5.3.1. нэгж байгуулах зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02002-ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Д)-д заасан баримт бичгийг хавсаргаж, Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.3.2. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй, тухайн ББСБ-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах ба зөвхөн тухайн компанийн оноосон нэрийг хэрэглэнэ.

5.3.3. ББСБ-ын оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлж буй нэгжийг салбар гэнэ.

5.3.4. ББСБ-ын оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

5.3.5. салбар, төлөөлөгчийн газар нь Хорооноос олгогдсон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх ба нэгж тус бүр нь зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

5.3.6. ББСБ-аас нэгж байгуулахаар хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, нэгж байгуулах нь тухайн ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн нэгжийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл ажлын 14 хоногийн дотор Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.3.7. тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийж, нэгжийн гэрчилгээг олгож, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

5.3.8. ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

5.3.9. ББСБ нь салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд албан бичгээр мэдэгдэнэ.

5.3.10. Хороо дараах үндэслэлээр ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ:

5.3.10.а. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй;

5.3.10.б. нэгжийн зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон;

5.3.10.в. энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

5.3.11. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шинээр олгохоос татгалзсан тохиолдолд нөхцөл шаардлага хангасны дараа ББСБ-аас салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл нэмж хүссэн өргөдлийг Хороонд дахин ирүүлж болно.

5.3.12. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 1 жилийн хугацаанд дахин зөвшөөрөл хүссэн өргөдлийг Хороо хүлээн авахгүй.

5.3.13. Нэгжийн зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож зөвшөөрлийн гэрчилгээг хураан авна:

5.3.13.а. нэгжийг татан буулгах ББСБ-ын удирдлагын шийдвэр;

5.3.13.б .холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй болон нэгжийн үйл ажиллагаа

нь тухайн ББСБ-ын хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосны үндсэн дээр гаргасан Хорооны даргын шийдвэр.

5.3.14. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэр нь салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

5.4. Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгох:

5.4.1. оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02002-ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Е)-д заасан баримт бичгийг хавсаргаж, Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.4.2. оноосон нэр солих өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь ББСБ-ын харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл ажлын 14 хоногийн дотор Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.4.3. ББСБ-ын оноосон нэр өөрчлөхийг зөвшөөрсөн шийдвэр гарсны дараа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хураамжийг төлсөн баримтыг үндэслэн Хороо холбогдох тэмдэглэгээг хийж баталгаажуулсан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгосны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

5.4.4. ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

### **Зургаа. Хүсэлтийг бүртгэх, бүртгэхээс татгалзах**

6.1. ББСБ-ын гүйцэтгэх удирдлага, хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02003 -ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Ж)-д заасан хавсаргах баримт бичгийг бүрдүүлж Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

6.2. Гүйцэтгэх удирдлага, хаяг байршил өөрчилсөнтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж үзээд ажлын 5 хоногийн дотор Хорооны мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгэж, тухайн байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

6.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5, 13.6-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгэхээс татгалзана.

### **Долоо. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох**

*/Энэ бүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 370 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

7.1. Хороо нь банк бус санхүүгийн төдөрхөй нэр төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

7.1.1. тухайн үйл ажиллагааны ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээг 2-улирал дараалан Хороонд ирүүлээгүй;

7.1.2. Хорооноос тогтоосон зохиетоу харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг төдөрхөй нэр төрлийн үйл ажиллагаанаас хамаарч 2 улирал дараалан хангаж ажиллаагүй бөл тухайн төдөрхөй нэр төрлийн үйл ажиллагааг;

~~7.1.3. тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авснаас хойш 3-улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй;~~

~~7.1.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.~~

~~7.2. Хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3-сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:~~

~~7.2.1. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй нь санхүү төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх бөлзөнгүй болсон;~~

~~7.2.2. Хорооноос тогтоосон журмыг зөрчиж, санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь удаа дараалан ирүүлээгүй, хяналт, шалгалт хийх боломжгүй болгосон;~~

~~7.2.3. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хоронгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;~~

~~7.2.4. дүрмийн сангийн эх үүсвэрийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд зарцуулсан.~~

~~7.2.5. Хорооноос хийсэн зайны хяналт шалгалтаар “Их эрдэлтэй” гэж үнэлэгдсэн, газар дээрх шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;~~

~~7.2.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.~~

~~7.3. Энэ журмын 7.1,7.2 т заасан үндэслэлээр банк бус санхүүгийн тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зорчил дутагдлыг арилгаж хэвийн үйл ажиллагаагаа хангасан тохиолдолд тухайн ББСБ-ын хүсэлтийг үндэслэн сэргээж болно.~~

~~7.4. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан өдрөөс хойш ББСБ нь дараах үйлдэл хийхийг хориглоно:~~

~~7.4.1. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэлээр шинээр аливаа гэрээ, хэлцэл байгуулах;~~

~~7.4.2. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэлээр тухайн өдрөөс өмнө байгуулсан аливаа гэрээ, хэлцэлд нэмэлт оорчлолт оруулах.~~

~~7.5. Тусгай зөвшөөрлөө сэргээлгэх хүсэлтэй ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавералтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн маягт СЗХ02002-ын дагуу өргөдөл гаргах ба 2 дугаар хавералт (Ё) д заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд хэвлэмэл болон нахимаар ирүүлнэ.~~

~~7.6. Хороо нь банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:~~

~~7.6.1. ББСБ өөрөө хүсэлт гаргасан;~~

~~7.6.2. Хорооноос банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;~~

~~7.6.3. тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авснаас хойш 4 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй;~~

~~7.6.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.~~

~~7.7. Хороо дараах үндэслэлээр ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно. Үүнд:~~

~~7.7.1. ББСБ өөрөө хүсэлт гаргасан;~~

~~7.7.2.Хорооноос баталж гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг удаа дараа хангаагүй, санхүү, төлбөрийн чадваргүй болсон;~~

~~7.7.3. дампуурсан эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан;~~

~~7.7.4. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэж тогтоогдсон нь харилцагчид ноцтой хохирол учруулах болсон;~~

~~7.7.5. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;~~

~~7.7.6. Хорооноос хийсэн зайны хяналт шалгалтаар “Их эрдэлтэй” гэж үнэлэгдсэн, газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан;~~

~~7.7.7.ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь удаа дараалан ирүүлээгүй, хяналт, шалгалт хийх боломжгүй болгож, тайланг 4 улирал дараалан Хороонд ирүүлээгүй;~~

~~7.7.8. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;~~

~~7.7.9. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.~~

~~7.8. Тусгай зөвшөөрлөө хүчингүй болгох хүсэлтэй ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн маягт СЗХ02004 ын дагуу өргөдөл гаргах ба 2 дугаар хавсралт (3)-д заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.~~

~~7.9. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Хороо энэ тухай олон нийтэд мэдээлэн, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн ББСБ ын хувийн хэрэгт хийж, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.~~

~~7.10. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос учирсан аливаа хохирлыг Хороо хариуцахгүй.~~

~~7.11. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гаргаснаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа нь дуусгавар болно.~~

~~7.12. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гаргасан өдрөө хойш тэдгээр үйл ажиллагааг үргэлжлүүлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.~~

### **Найм. Хяналт, хариуцлага**

8.1. Холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрийн биелэлт болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо хяналт тавьж, шалгалт хийнэ.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.


Санхүүгийн зохицуулах хоргоны 2016 оны  
03 дугаар сарын 11 өдрийн 71 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан  
"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны  
зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт

УХА0410 5043239

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Д/д	Маягтын код	Өргөдлийн маягтын зориулалт
1	СЗХ02001	Банк бус санхүүгийн байгууллага байгуулах, Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягт
2	СЗХ02002	ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, нэгж байгуулах, оноосон нэр өөрчлөх, хоёрдогч өглөг байршуулах, тусгай зөвшөөрөл сэргээх зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягт
3	СЗХ02003	Гүйцэтгэх удирдлага, хаяг, байршлын өөрчлөлт бүртгэх маягт
4	СЗХ02004	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг хүчингүй болгох хүсэлт гаргах

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны  
 71 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан  
 "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны  
 зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралт



Маягт СЗХ02001  
 (ББСБ)

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ,  
 БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
 ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он	Сар	Өдөр
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол		
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)		
Улсын бүртгэлийн дугаар			
Регистрийн дугаар			
<b>Хэсэг 1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлөө сөнгөнө уу.</b>			
<input type="checkbox"/> Зээл <input type="checkbox"/> Факторингийн үйлчилгээ <input type="checkbox"/> Төлбөрийн баталгаа гаргах <input type="checkbox"/> Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах <input type="checkbox"/> Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ <input type="checkbox"/> Гадаад валютын арилжаа <input type="checkbox"/> Итгэлцлийн үйлчилгээ <input type="checkbox"/> Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх <input type="checkbox"/> Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх <input type="checkbox"/> Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа			
<b>Хэсэг 2. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл</b>			
Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан уу?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол дараах мэдээллийг бөглөнө үү.			
Ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бэ?			
Өмнө нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан уу?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол хэдэн онд?			
Татгалзсан шалтгаан?			
Үүсгэн байгуулагдсан огноо	Он	Сар	Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай		
Хаяг байршил	Аймаг/ хот		
	Сум/дүүрэг		
	Баг/хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
Холбоо барих утас			

Цахим хуудас				
Цахим хаяг				
<input type="checkbox"/> Харилцах	Банкны нэр			
	Дансны дугаар			
	Валютын төрөл			
	Үлдэгдэл	<input type="checkbox"/>		<input type="checkbox"/>
<input type="checkbox"/> Хадгаламж	Банкны нэр			
	Дансны дугаар			
	Валютын төрөл			
	Үлдэгдэл	<input type="checkbox"/>		<input type="checkbox"/>
<b>Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:</b>				
Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо (ш)	Хувьцааны төрөл	ХНХ-н хэмжээ ( <input type="checkbox"/> )	ХНХ-д эзлэх хувь (%)
		<input type="checkbox"/> ДЭХ <input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ <input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ <input type="checkbox"/> ЭХ		
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)				
<b>Хэсэг 3. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл</b>				
Үүсгэн байгуулагч этгээд нь аль болохыг сонгоно уу.			<input type="checkbox"/> Хуулийн этгээд <input type="checkbox"/> Иргэн	
<b>1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.</b>				
Хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол Англи			
Улсын бүртгэлийн дугаар				
Регистрийн дугаар				
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар	Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани			
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай			
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл				
Үйл ажиллагааны орлого	<input type="checkbox"/>			
Үйл ажиллагааны зардал	<input type="checkbox"/>			
Үйл ажиллагааны ашиг	<input type="checkbox"/>			
Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө	<input type="checkbox"/>			
Хаяг байршил	Аймаг/ хот			
	Сум/дүүрэг			
	Баг/хороо			
	Гудамж, байр			
	Тоот			
	Холбоо барих утас			
Цахим хуудас				
Цахим хаяг				
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.				
Оноосон нэр				
Регистрийн дугаар				

Компанийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани	<input type="checkbox"/> Хязгаарлагдмал компани	хариуцлагатай				
Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох	<input type="checkbox"/> Толгой	<input type="checkbox"/> хараат					
	<input type="checkbox"/> охин	<input type="checkbox"/> зэргэлдээ					
Байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр		
Үйл ажиллагааны төрөл							
Хаяг	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
Холбоо барих утас							
Цахим хуудас:							
Цахим хаяг:							
<b>2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.</b>							
Овог							
Нэр							
Регистрийн дугаар							
Албан ёсны хаяг байршил							
Эрхэлж байгаа ажил, албан тушаал							
Ажлын хаяг							
Эзэмшсэн мэргэжил							
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	<input type="checkbox"/>						
Харилцах дансны үлдэгдэл	<input type="checkbox"/>						
Хадгаламжийн дансны үлдэгдэл	<input type="checkbox"/>						
<b>Хэсэг 4. Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл</b>							
